

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирлын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1127... дугаар тушаалын хавсралт



	ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид суралцагч элсүүлэх журам ШУТИС-СҮ-ЖУ13	Эхний хэвлэлт	2023.05.18
		Өөрчилсөн огноо	2026.04.10
		Өөрчлөлтийн дугаар	3

**ШУТИС-ИЙН ХАРЬЯА ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧ  
ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**  
(2026-2027 оны хичээлийн жил)

**Боловсруулсан:**

ШУТИС-ийн харьяа ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН АЛБА

**Дэмжсэн:**

ШУТИС-ийн харьяа ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

**Баталсан:**

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ



## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ .....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ .....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА .....	3
ЗУРГАА. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	4
ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ .....	4
НАЙМ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ .....	5
ЕС. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ .....	6
АРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ .....	6
АРВАН НЭГ. БУСАД .....	7



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид (Цаашид “Технологийн коллеж” гэх) элсэн суралцахаар хүсэлт гаргагчийн элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Сургуулийн материаллаг бааз, анги кабинетын хүрэлцээ зэргээс хамааран шинээр элсэх суралцагчдын тоог ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Удирдах зөвлөл тогтооно.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү журам нь ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид 2026-2027 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх үйл явцыг хамарна.

## ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Дээд боловсролын тухай хууль;
- 3.2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03-р сарын 20-ны өдрийн А/146 дугаар “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай” тушаал;
- 3.3. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл (Боловсролын Яам 2024.08.28-ны өдөр)

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Элсэлтийн шалгалт** гэж элсэх хүсэлтэй суралцагчдын суурь боловсролын мэдлэг, чадварын түвшинг тогтоох зорилго бүхий шалгалтыг;
- 4.2. **Бүртгүүлэгч** гэж технологийн коллежид элсэх хүсэлт гаргаж бүртгүүлсэн иргэн, түүний эцэг, эх, асран хамгаалагчийг;
- 4.3. **Элсэгч** гэж хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан иргэн;
- 4.4. **Элсэлтийн систем** гэж элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- 4.5. **Элсэлтийн ажлын хэсэг** гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- 4.6. **Элсэлтийн бүртгэл** гэж технологийн коллежид элсэн суралцахаар элсэлтийн системд нэвтэрч бүртгэл хийлгэх үйл ажиллагааг;
- 4.7. **Элсэлтийн бүртгэлийн хураамж** гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулах мөнгөн хөрөнгийг;
- 4.8. **Хөтөлбөр баталгаажуулалт** гэж элсэлтийн шалгалтад тэнцэн, онооны эрэмбэлэлтийн дагуу хяналтын тоонд багтан технологийн коллежид суралцах хөтөлбөр сонгон, “Суралцах эрхийн бичиг” авах үйл явцыг;
- 4.9. **Элсэлт баталгаажуулалт** гэж элсэлтийн баталгаажуулалтын мөнгөн төлбөр төлж, суралцах гэрээ байгуулах үйл явцыг;
- 4.10. **Хяналтын тоо** гэж тухайн жилд элсүүлэх элсэгчийн тоог;
- 4.11. **Шалгуулагч** гэж элсэлтийн шалгалт өгч буй бүртгүүлэгчийг.

## ТАВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. **ШУТИС-ийн харьяа технологийн коллежийн захирал:**
  - 5.1.1. Элсэлтийн ажлын хэсгийг байгуулж, удирдлагаар хангаж ажиллана.
  - 5.1.2. Элсэлтийн ажлын хэсгийн ажлын төлөвлөгөө, төсвийг батална.
  - 5.1.3. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
  - 5.1.4. Элсэлтийн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн тайлантай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.



## 5.2. Элсэлтийн ажлын хэсэг:


- 5.2.1. Элсэлтийн ажлын хэсэг нь сургалтын албаны дарга, ажилтан, тэнхимийн эрхлэгч, захирлын туслах, шалгалтын материал засч, дүнг нэгтгэх багш болон бусад нэгжийн бүрэлдэхүүнтэй байна.
- 5.2.2. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, төсвийг элсэлтийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга захирлаар батлуулж, гишүүд хэрэгжүүлнэ.
- 5.2.3. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.2.4. Элсэлтийн үеийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.
- 5.2.5. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг бэлтгэж, захирлын зөвлөлийн хуралд тайлагнана.
- 5.2.6. Байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд аливаа байдлаар сөргөөр нөлөөлөх ташаа мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байх, ёс зүйг эрхэмлэх;
- 5.2.7. Элсэлтийн шалгалтын дэг, журам зөрчсөн, ямар нэгэн дутагдал гаргаж буй бүртгүүлэгчид зохих ёсны шаардлага тавих;

### **ЗУРГАА. ЭЛСЭХИЙГ ХҮСЭГЧДИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 6.1. Элсэхийг хүсэгчдэд тавих ерөнхий шаардлага:
  - 6.1.1. Суурь боловсрол эзэмшсэн байх;
  - 6.1.2. Бүртгүүлэгч гадаад оронд суурь боловсрол эзэмшсэн бол Боловсролын яамнаас Монгол Улсын суурь боловсролтой дүйцүүлсэнийг нотлох тодорхойлолт гаргуулсан байх;
  - 6.1.3. Сонгосон хөтөлбөрөөрөө суралцах сонирхолтой байх.
- 6.2. Элсэлтийн бүртгэл:
  - 6.2.1. 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 6 дугаар сарын 19-ний өдрийн 10:00 цаг хүртэл <https://elself.edu.mn/> хаягтай элсэлтийн системээр дамжуулан улс орон даяар цахим хэлбэрээр зохион байгуулна.
  - 6.2.2. Бүртгүүлэгч нь элсэлтийн системд Регистрийн дугаараа оруулснаар төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс иргэний бүртгэлийн мэдээлэлийг татаж бүртгэл үүсгэнэ.
  - 6.2.3. Бүртгүүлэгч “Элсэлтийн журам”-тай танилцсаны дараа бүртгэлийн хураамж төлнө.
  - 6.2.4. Элсэлтийн бүртгэлийн хураамж 40,000 (дөчин мянга) төгрөг байна. Элсэлтийн бүртгэл үүсгэсэн бүртгүүлэгч QR цахим төлбөрийн системээр дамжуулан бүртгэлийн хураамжийн гүйлгээг хийнэ.  
(Бүртгэлийн хураамж төлөх дансны дугаар: Хаан банкны 48000500 5031748624 Дансны нэр: ШУТИС-ийн харьяа Технологийн коллеж)
  - 6.2.5. Бүртгэлийн хураамжийг элсэлт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулах тул буцаан олгохгүй.
  - 6.2.6. Элсэлтийн бүртгэлийн хураамж төлсөн бүртгүүлэгчийн элсэлтийн бүртгэл баталгаажиж, системээс бүртгэлийн дугаар хуваарилагдана.

### **ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ**


- 7.1 Элсэлтийн системд бүртгэл баталгаажсан бүртгүүлэгч “Бүртгэлийн дугаар бүхий бүртгэлийн хуудас”-аар элсэлтийн шалгалтад орно.
- 7.2 Элсэлтийн шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10.00 цагт ШУТИС-ийн хичээлийн VIII байранд дараах үе шаттайгаар зохион байгуулагдана. Үүнд:



- Математик, физикийн хичээлийн агуулгаар авах шалгалт. Үүнд: математикийн хичээлийн агуулга 70%, физикийн хичээлийн агуулга 30%-ийн бүтэцтэй байна.
  - Ярилцлагын шалгалт. Бичгийн шалгалтад тэнцсэн бүртгүүлэгчээс ярилцлагын шалгалт авна.
- 7.3 Бүртгүүлэгч шалгалт өгөхөөр ирэхдээ дараах материалыг авч ирнэ. Үүнд:
- 7.3.1 Төрсний гэрчилгээ (иргэний үнэмлэх);
  - 7.3.2 Элсэлтийн системээс өөрийн зурагтай бүртгэлийн хуудсыг хэвлэж ирэх;
  - 7.3.3 Хар балын харандаа;
  - 7.3.4 Баллуур.
- 7.4 Шалгалтын үндсэн зарчим
- 7.4.1 Шалгалтын даалгавар, шалгуур түвшинд нь тохирсон, үнэн зөв, шалгуулагчид ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт өгөх болон тэдний сэтгэн бодох чадварыг нээн илрүүлэх боломжтой байх;
  - 7.4.2 Шалгалт шударга, ил тод байх;
- 7.5 Шалгалтын сэдвийг тухайн хичээлүүдийн суурь боловсролын агуулгын хүрээнд боловсруулна.
- 7.6 Элсэлтийн ажлын хэсэг шалгалтын сэдвийг шалгалт эхлэхээс нэг цагийн өмнө шалгуулагчдын тоогоор хувилж бэлтгэнэ.
- 7.7 Элсэлтийн шалгалтын үйл явцын дэгийг элсэлтийн ажлын хэсгийн дарга батална.
- 7.8 Шалгалтын үйл явцыг Ажлын хэсгийн даргын баталсан дэгийн дагуу зохион байгуулна.
- 7.9 Шалгалтын дүн, онооны эрэмбэлэлт.
- 7.9.1 Бичгийн болон ярилцлагын шалгалтын онооны нийлбэр дүнгээр бүртгүүлэгчдийн шалгалтын дүнг эрэмбэлнэ.
  - 7.9.2 Шалгалтын дүнг шалгалт зохион байгуулагдсан өдөр элсэлтийн цахим систем, технологийн коллежийн facebook хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.
  - 7.9.3 Бүртгүүлэгч шалгалтын онооны эрэмбээр хэдэд жагссанаа Элсэлтийн системээс харах боломжтой.
  - 7.9.4 Бүртгүүлэгч нь шалгалтын оноо, үр дүнтэй холбоотой өөрийн материалыг шалгах хүсэлт гаргаж болно.

### **НАЙМ. ХӨТӨЛБӨР СОНГОЛТ, ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ**

- 8.1 Элсэлтийн хөтөлбөр сонголтын үйл ажиллагааг элсэлтийн цахим систем болох <https://elselt.edu.mn/> нэртэй веб хуудсаар дамжуулан цахимаар явуулна.
- 8.2 Хөтөлбөр сонгох зарим, үйл ажиллагааны дараалал, хөтөлбөр сонголт эхлэх, дуусах огноог элсэлтийн Ажлын хэсэг тодорхойлж, мэдээллийг элсэлтийн цахим хуудсаар дамжуулан нийтэд урьдчилан хүргэнэ.
- 8.3 Бүртгүүлэгч элсэлтийн системд нэвтрэн, хяналтын тоонд багтсан эсэхээ урьдчилан шалгаж болно.
- 8.4 Бүртгүүлэгч элсэлтийн хяналтын тоонд багтаагүй бол өөрийн өмнө эрэмбэлэгдсэн бүртгүүлэгчдийн хөтөлбөр сонголтын үр дүнг харгалзан эрэмбэ дээшилж, хяналтын тоонд багтах боломжийг хүлээж болно.
- 8.5 Хөтөлбөр сонгох үйл ажиллагаа хуваарьт өдрүүдэд үргэлжлэх ба бүртгүүлэгч өөрийн сонгосон хөтөлбөрийг баталгаажуулах төлбөр болох 150.000 төгрөгийг 1 цагийн дотор төлж, хөтөлбөр баталгаажуулалт хийнэ.
- 8.6 Бүртгүүлэгч 1 цагийн дотор хөтөлбөр баталгаажуулалт хийгээгүй тохиолдолд тухайн



- хөтөлбөрийг сонгохоос татгалзсан гэж үзэж, жагсаалтаас хасна.
- 8.7 Бүртгүүлэгч анх сонгож бүртгүүлсэн хөтөлбөрөөс гадна бүртгүүлэгчийн тоо хяналтын тооноос бага байгаа тохиолдолд бусад хөтөлбөрөөс шууд сонголт хийж болно.
  - 8.8 Хөтөлбөр баталгаажуулалт хийсэн тохиолдолд “ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид суралцах эрхийн бичиг” цахимаар олгогдох ба “Суралцах гэрээ”-тэй танилцсанаар Элсэлт баталгаажина.
  - 8.9 Хөтөлбөр сонголтыг баталгаажуулсан 150.000 төгрөгийг элсэгчийн сургалтын төлбөрт тооцно. Элсэгч баталгаажуулсан хөтөлбөрөө цуцлах, эсвэл сургалтын явцад суралцахаас татгалзсан тохиолдолд дараагийн бүртгүүлэгчийн хөтөлбөр сонгох боломжийг хаасан үндэслэлээр хөтөлбөр баталгаажуулалтын төлбөрийг буцаан олгохгүй.
  - 8.10 Элсэлт авч буй хөтөлбөрийн чиглэлээр улсын болон олон улсын олимпиадад эхний 5 байр эзэлсэн бол амжилтыг харгалзан шалгалтгүйгээр шууд элсүүлж, суралцах эрхийн бичиг олгоно.
  - 8.11 ШУТИС-ийн харьяа Технологийн коллежоос улс орон даяар Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн суралцагчдын дунд зохион байгуулсан уралдаан, тэмцээнд эхний 3 байр эзэлсэн бүртгүүлэгчийг элсэлтийн шалгалтгүйгээр элсүүлж, баталгаажуулалтын хуудас олгоно.

### **ЕС. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ**

- 9.1 Элсэлт баталгаажуулсан элсэгч элсэлтийн системээс “Суралцах эрхийн бичиг”, “Суралцаг гэрээ”-г хэвлэн 2026 оны 6 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд Сургалтын албанд ирж, бүртгэлээ хийлгэнэ.
- 9.2 Элсэгч нь доорх материалыг бүрдүүлэн, асран хамгаалагчийн хамт Сургалтын албанд ирнэ. Үүнд:
  - Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх)
  - Суурь боловсролын гэрчилгээ
  - Төрсний гэрчилгээний хуулбар
  - Эцэг эх, асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний хуулбар
  - 2 хувь цээж зураг /сүүлийн 6 сарын/
  - Жилийн сургалтын төлбөрийг бүрэн төлсөн байх
  - Суралцах эрхийн бичиг (элсэлтийн вебээс хэвлэх)
  - Суралцах гэрээ (элсэлтийн вебээс хэвлэх)
  - Элсэгчийн анкет (элсэлтийн вебээс хэвлэх)
- 9.3 Суралцагчийн материалаар хувийн хэрэг бүрдүүлж төгсөх үед хүлээлгэж өгнө.
- 9.4 Бүртгүүлэгч зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй тохиолдолд тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэж, шаардлага хангасан бүртгүүлэгчийг нөхөн элсүүлнэ.

### **АРАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ**

- 10.1 Элсэлт авч буй хөтөлбөрийн чиглэлээр 2025-2026 оны хичээлийн жилд улсын болон олон улсын олимпиадад 1-ээс 10-р байрт шалгарсан элсэгчдэд эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30-100 хувийн тэтгэлэг олгоно.
- 10.2 ШУТИС-ийн харьяа Технологийн коллежоос улс орон даяар Ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн суралцагчдын дунд зохион байгуулсан уралдаан, тэмцээнд эхний 3 байр эзэлсэн элсэгчид эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 10-30 хувийн тэтгэлэг олгоно.

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн  
захирлын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны  
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



#### АРВАН НЭГ. БУСАД

- 11.1 Элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох аливаа маргаан, зөрчлийг бичгээр элсэлтийн ажлын хэсэг хүлээн авч, шийдвэрлэнэ.
- 11.2 Хичээлийн жилийн намрын улиралд анги дүүргэлтийг нөхөж, нэмэлт элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж болно.
- 11.3 Нэмэлт элсэлтийн үйл ажиллагааны хөтөлбөр, удирдамжийг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Элсэлтийн ажлын хэсгийн дарга батална.
- 11.4 Хичээлийн жилийн хавар, намрын улиралд анги дүүргэлтийг нөхөж, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан суралцагчийг 1, 2 дугаар ангид шилжүүлэн суралцуулж болно.

--- оОо ---